



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 17/25

Чингис хот

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сариг багт оношлогдсон гахайн африкийн мялзан өвчин 2025 оны 01 дүгээр сарын 08-ны А/08 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоож халдвар, хамгааллын дэглэм мөрдүүлж, голомтын бүсийн амьтныг устгаж, тэмцэх хариу арга хэмжээг түргэн шуурхай авч ажилласны үр дүнд голомт, сэжигтэй бүсэд нэмж өвчлөл илрээгүй тул 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн дэглэмийг бууруулж хязгаарлалтын дэглэмд шилжүүлсүгэй.

2. Гахайтай иргэдийг байнгын мэдээллээр хангаж, өвчний шинж тэмдэг шинээр илэрсэн тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагуудад шуурхай мэдэгдэж ажиллахыг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (Д.Сандагдорж)-д даалгасугай.

3. Голомтын болон сэжигтэй бүсийн айл өрхүүдийн гахайд үзлэг тандалт, халдваргүйтгэлийн ажлыг 14 хоногийн хугацаанд хийж ажиллахыг "Абока" мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Ж.Амгалан)-д даалгасугай.

4. Голомтын болон сэжигтэй бүсээр дайран өнгөрч буй хүн, амьтанд тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Г.Лхагвабаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР